

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР

№	Зорилт	1.1.	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Хэрэгжилт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах	1.2.	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	Жилдээ	- Дэмжиж хамтран ажилласан байх - Олон нийтэд хүргэсэн мэдээ, мэдээллийг сурталчилсан тоо	- 12 ба дээш мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.	Байгууллагын цахим хуудасны Авлигатай тэмцэх үйл ажиллагаа буланг шинээр гаргаж авлигатай тэмцэх төлөвлөгөө, тайлан, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар, урьдчилсан мэдүүлэг хянасан дүгнэлт, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд булангууд ил байршуулан холбогдох мэдээллийг тухай бүр оруулан ажилласан. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргадаг 14 хоног тутамд гаргадаг Авлигатай тэмцэх газрын мэдээлэл нэвтрүүлэг, найруулагч У.Пүрэвжав: Ирээдүйг хамгаалах, хайрлах хамгийн зөв арга бол авлигыг тэвчих, том толгойт: цахим хичээл, хуулийн засаглал:Авлига, албан тушаалын гэмт хэрэгт хуулийн хатуу хариуцлага тооцдог, ялын бодлогыг чангатгах цаг болсон, Д.Дагиймаа:хүүхдэд багаас нь зөв зүйлийг таниулах ёстой зэрэг нэвтрүүлэг, сторкуудыг байгууллагын цахим хуудасны урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх булан байршуулсан. Мөн Авлигатай тэмцэх газарт хэрхэн өргөдөл, гомдол, мэдээлэл гарах вэ? зурагт танилцуулгыг цахим хуудасны нүүрэнд байршуулсан. Мөн байгууллагын олон нийтийн сүлжээ /фэйсбүүк/-гээр дамжуулан авлигын эсрэг үйл ажиллагаа сурталчилсан. 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээллийн самбарт Авлигатай тэмцэх газраас бэлгэсэн контент, зурагт хуудас, нугалбар зэрэг мэдээллийг байршуулан олон нийтэд хүргэн ажилласан.

		1.2.	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	Жилдээ	- Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх	- Мэдээ, мэдээлэл нь олон нийтэд хүрсэн байна.	Авлигатай тэмцэх газраас олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 2022 онд санаачилан хэрэгжүүлсэн арга хэмжээг салбарын хэмжээнд Авлигаас ангид газрын харилцаа сэдэвт арга хэмжээг аймгийн ГХБХБГ-тай хамтран зохион байгуулсан.
		1.3.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах	Жилдээ	- Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх, - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх	- Мэдээлэл тогтмол шинэчлэгдсэн байна.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг байгууллагын үүдэнд байршуулсан. Авлигатай тэмцэх газраас нээсэн шударга ёс, хөгжил дэвшилд самбар хариуцсан албан хаагчид класс рүүмд нэгдэж мэдээллийг авч самбарын мэдээллийг шинэчлэн ажилласан. 2022 оны жилийн эцсийн байдлаар 4 удаа шинэчилсэн.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1.	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-т хүргүүлж, албан хаагчдаа холбогдох сургалтад хамруулсан байх	Жилдээ	- Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-Сургалтад хамрагдсан байна.	2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан Эрх бүхий албант тушаалтнуудад зориулсан давтан сургалтад, 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн цахим сургалтад шинээр томилогдсон албан хаагчдыг 6 албан хаагчийг тус тус хамруулсан.
		2.2.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх	Жилдээ	- Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-Сургалтад хамрагдсан байна.	Тус газар нь Газрын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Геодези, зураг зүйн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажилладаг. Газрын харилцааны салбарын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан бөгөөд зөвлөгөөнд аймгийн Газрын харилцаа, барилга,

						<p>хот байгуулалтын газрын дарга, Газрын удирдлагын хэлтсийн дарга, Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга, нэгжийн дарга болон тус газрын удирдах албан тушаалтнууд оролцсон. Тус зөвлөгөөнд авлигын индексийг бууруулах ажлын хүрээнд “Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөл, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт, мэдээлэл хийлгэх хүсэлтийг тус газрын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 1/60 тоот албан бичгээр хүргүүлж хамтран ажилласан.</p> <p>Дээрх зөвлөгөөнд Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Ч.Жаргалбаатар, УССГХ-ийн ажилтан, комиссар С.Атартүвшин, Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Д.Цэнд-Аюуш нар ирж сургалт танилцуулга хийсэн.</p> <p>2022 оны 04 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институттэй хамтран “Төрийн захиргааны удирдлага ба гүйцэтгэлийн төлөвлөлт” сэдэвт богино хугацааны захиалгат сургалтыг зохион байгуулж 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнүүдийг хамруулсан. Нийт 45 албан хаагч хамруулсан. Сургалтад төрийн албан хаагчийн ёс зүйн сэдэв, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, ХАСУМ, ХАСХОМ мэдүүлэх зэрэг сэдвээр тус байгууллагын ЭБАТ, Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа сургалт хийсэн.</p>
--	--	--	--	--	--	---

3	Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх	3.1.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Тухай бүр	- Зөвлөмжийн тоо	- Зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.	2022 онд Авлигатай тэмцэх газраас зөвлөмж ирээгүй байна.
		3.2.	Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлж, нотлох баримт болон шинжээчийн дүгнэлтийг гаргаж хүргүүлэх	Тухай бүр	- Мэдэгдэл, нотлох баримт гаргуулах албан тоотын тоо - Шинжээчийн дүгнэлт гаргах тогтоолын тоо	- Нотлох баримт, шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна.	2022 оны байдлаар Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлстийн мөрдөгчийн шинжээч томилох тухай 6 тогтоол ирсэн байна. Тогтоолын хүрээнд шинжээчийн дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Газрын даргын тушаалаар байгуулан ажиллаж, хэмжил зураглалын ажлыг гүйцэтгэн, дүгнэлтийг хүргүүлэн ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар шүүх болон Авлигатай тэмцэх газарт нийт 33 шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна. Авлигатай тэмцэх газартай дундын мэдээллийн сан байгуулах, хамтран ажиллах 2022/44, 37 тоот гэрээг 2022 оны 02 сарын 17-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу сервис үйлчилгээний жагсаалтыг хүргүүлсэн бөгөөд АТГ-ын 5 албан хаагчид egazar.gov.mn системд нэвтрэх эрхийг Газрын даргын 2022 оны А/60 тоот тушаалаар олгож иргэн, хуулийн этгээдийн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой мэдээллийг тухай бүр авах боломжийг бүрдүүлсэн.
		3.3.	Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Тухай бүр	- Арга хэмжээний тоо	- Зөрчил арилсан байна.	Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 06/7205 тоот “Бүртгэлийн алдаа засварлаж зөрчил аргилгах” талаарх албан бичгийн хүрээнд Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлийн алдааг засаж эргэн мэдэгдэх албан бичгийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Архангай аймгийн ГХБХБГ, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд, Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаанд тус тус хүргүүлсэн.

4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах	Жилдээ	- Арга хэмжээний тоо	- Тодорхой арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Тус байгууллага Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг хуулийн этгээдэд олгох урьдчилсан дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулдаг. Дээрх ажлын хэсэгт Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо, Газар зохион байгуулагчдын холбооноос төлөөлөл оролцуулан хурлыг зохион байгуулдаг бөгөөд 2021 оноос эхлэн тусгай зөвшөөрлийн материалыг цахим системээр дамжуулан авч эхэлсэн. Төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтын ажиллагааны хүрээнд УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”, Геодези, зураг зүйн тухай хууль, Газрын тухай хуулийг судалж холбогдох байгууллагад саналаа хүргүүлсэн. Дээрх ажлын хүрээнд Монголын кадастрын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал Н.Ганхуяг нар Хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Бэлчээрийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг сайжруулах, малын гаралтай бүтээгдэхүүний үнэлэмжийг бэлчээрийнх нь чанар, төлөв байдал, малчдын мал маллагааны онцлог, үр нөлөөнд үндэслэн тооцох замаар бэлчээрийн тогтвортой менежментийг хэвшүүлэх, улмаар малчдын орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, хариуцлагатай үйлдвэрлэлийг төлөвшүүлэх зорилго юм. 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Монголын Газар зохион байгуулагчдын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Салбарын хөгжлийг дэмжих, хууль
---	--	------	--	--------	----------------------	---	--

						эрх зүйн орчныг боловсронгуй болгох, газар зохион байгуулалт, газрын кадастр, газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлуудыг хийж гүйцэтгэх арга зүй, норм, стандартуудыг боловсруулах, сайжруулах, хэрэгжилтэд хяналт тавих, салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэжлийн ажлын чанарт хөндлөнгийн хяналт тавих чиглэлээр хамтран ажиллана.
	4.2.	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	Жилдээ	- Гэрээний тоо	- Гэрээнд туссан байна.	Тус агентлагийн албан хаагчдаас болон бусад холбогдох байгууллагаас боловсруулсан гэрээний төсөлд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлын тусган холбогдох албан тушаалтнуудаар батлуулан ажиллаж байна. 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 103 иргэн, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. Үүнээс <ul style="list-style-type: none"> - Ажил гүйцэтгэх гэрээ 42 - Хамтран ажиллах гэрээ 28 -Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ 95 - Зөвлөх үйлчилгээний гэрээ 17 -тусгай хэрэгцээний газарт газар ашиглуулах гэрээ 5 - Хөдөлмөрийн гэрээ 4 - бусад 9
	4.3.	Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачилга өрнүүлэх	Жилдээ	- Арга хэмжээний тоо	- Удирдлагын манлайлал бий болсон байна.	Байгууллагын удирдлага авлигын эсрэг удирдлагын манлайллыг үзүүлэн аймгийн ГХБХБГ болон нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга нарт зохион байгуулж буй сургалтын хөтөлбөрт Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөл, цаашид анхаарах асуудлыг тусган оруулан Авлигатай тэмцэх газартай хамтран ажилласан.
	4.4.	Авлигатай тэмцэх газрын холбогдох албан хаагчдыг Газрын	Жилдээ	- Арга хэмжээний тоо	- Нөхцөл бүрдсэн байна.	Авлигатай тэмцэх газартай дундын мэдээллийн сан байгуулах, хамтран ажиллах 2022/44, 37

			кадастрын мэдээллийн системээс иргэн, хуулийн этгээдийн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн талаар мэдээлэл авах боломж нөхцөлийг бүрдүүлэх				тоот гэрээг 2022 оны 02 сарын 17-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу сервис үйлчилгээний жагсаалтыг хүргүүлсэн бөгөөд АТГ-ын 5 албан хаагчид egazar.gov.mn системд нэвтрэх эрхийг Газрын даргын 2022 оны А/60 тоот тушаалаар олгож иргэн, хуулийн этгээдийн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой мэдээллийг тухай бүр авах боломжийг бүрдүүлсэн.
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах	5.1.	Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний талаар (И-Монголиад холбосон, автоматжуулсан үйлчилгээг оруулна) мэдээлэл	Жилдээ	- Мэдээллийн тоо	- Үйлчилгээ цахим болсон байна.	е-монголиа системд нэмэлтээр газар эзэмших гэрээний лавлагаа, газар эзэмших гэрчилгээний лавлагаа, газар ашиглах эрхийн лавлагаа, Газрын үнэлгээний лавлагаа, газрын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа зэрэг 5 төрлийн лавлагааны сервис үйлчилгээ болон загварыг боловсруулж Emongolia системд 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтэрсэн. Нийт 42 төрлийн үйлчилгээг тус системд цахимжуулсан.
		5.2.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн үйлчилгээний зохион байгуулалтыг өөрчилсөн, стандартыг шинэчилсэн талаар мэдээлэл	Жилдээ	- Мэдээллийн тоо	- Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	Орон зайн өгөгдлийн стандартын тохирлын орчныг хөгжүүлэх чиглэлээр бусад байгууллагуудын боловсруулж буй стандартын төслүүдэд салбарын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартуудтай нийцүүлж санал боловсруулан хүргүүлж ажилласан.
		5.3.	Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор өөрчлөлт оруулсан дүрэм, журмын талаар мэдээлэл	Жилдээ	- Мэдээллийн тоо	- Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	Салбарын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол шийдвэр, байгуулагын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудасны эрх зүйн акт болон хууль, эрх зүйн буланд тогтмол байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж баталж Хууль, зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, хэм хэмжээний актад бүртгүүлсэн. Журмыг шинэчлэн батлагдсанаар

						газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зургийг иргэн, хуулийн этгээд “ДАН” системээр дамжуулан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд нэвтэрч хэвлэж авах боломжтой болсон. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ, эрхийн гэрчилгээ, кадастрын зургийн хөтлөлтөнд хяналт тавих боломжтой болсон. 2021 оны 11 сараас хойш улсын хэмжээнд нийт 21961 эрхийн гэрчилгээг цахимаар олгосон.	
		5.4.	Авлигын эрсдэлийн үнэлгээ, үйл ажиллагаанд мониторинг, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан эсэх талаар мэдээлэл	Жилдээ	- Мэдээллийн тоо	- Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	2021 оны Шудрага байдлын үнэлгээний тайлантай танилцаж, өөрийн байгууллага болон салбарын хэмжээнд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дүн шинжилгээний дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний саналыг Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөж байна.
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	6.1.	Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэх.	Жилдээ	- Мэдээллийн тоо	- Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	Байгууллагын үндсэн цахим хуудас / www.gazar.gov.mn /-ны Хэвийн үйл ажиллагааг ханган 92 мэдээ, сурвалжлага, 27 ярилцлага, 5 шторк, 21 постер, 6 шууд дамжуулалт, FM радиогийн 2 удаагийн шууд дамжуулалт, Монголын хурд агентлагийн үйл явдлын мэдээ 8 удаа, видео 8 минутын 1 нэвтрүүлэг, 2 анонс, Univision iptv зориулж 2 баннер зохион байгуулж, байгууллагын албан ёсны олон нийтийн сүлжээнд 269 мэдээг тус тус оруулан ажилласан. Англи хэл дээрх цахим хуудсанд мэдээ нийтлэх эрх бүхий хэрэглэгч зурган мэдээлэл оруулахад алдаа гарсныг засварлан хэвийн үйл ажиллагаанд оруулсан. Цахим хуудасны ил тод байдлыг сайжруулах ажлын хүрээнд, нүүр хуудас хэсэгт Авлигатай тэмцэх үйл ажиллагааны ил тод, байдлын нэмэлт булан байршуулах хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн

						<p>цахим систем Геопортал www.nsd.gov.mn-г хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд цахим системд хэрэглэгчийн хандалтыг өдөр, сар, улирал, жилээр бүргэх хөгжүүлэлтийг хийж хэрэглээнд нэвтрүүлсэн. Цахим хуудсанд www.gazar.gov.mn-ны wild card SSL сертификатыг тохируулсан. Ингэснээр вэб сервер болон хэрэглэгчийн хооронд дамжигдаж буй мэдээллийг тусгай алгоритмын аргаар кодчилж мэдээллийг дундаас алдахгүй байх нөхцөл бүрдсэн.</p> <p>Салбарын төрийн архивын цахим системд хэрэглэгчийн системийг хурууны хээ уншигч төхөөрөмжтэй интеграци хийн төрийн мэдээлэл солилцооны ХУР системээс татаж бүртгэх хөгжүүлэлтийг хийсэн. Мөн хадгаламжийн нэгж дээр QR код гаргах хөгжүүлэлтийг хийж POS принтер, QR код уншигч төхөөрөмжүүдтэй холбосон. Шинээр хөгжүүлж буй Хот байгуулалтын кадастрын систем www.urban.gov.mn-г үндсэн сервер дээр шинэчлэн тохируулах, өмнөх системийг old.urban.gov.mn хаяг руу чиглүүлэх ажлыг Үндэсний дата төв УТҮГ болон Шонхор Софт ХХК-тэй хамтран зохион байгуулсан.</p> <p>Хот байгуулалтын кадастрын системийн орон зайн бусад үйлчилгээ хэсэгт газрын нэгж талбар, газар хөдлөлтийн ерөнхий мужлал, газар хөдлөлтийн бичил мужлал, хөрс, ургамал, геологи, гидрогеологи, геоморфологи зэрэг 8 төрлийн өгөгдлийн Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц “Геопортал”-аас оруулан холболтуудыг хийсэн. Хот байгуулалтын кадастрын системийн хөгжүүлэлтийн urban.bits.mn-д байршиж байсан geoserver-ын байгууллагын үндсэн geoserver болох geo.nsd.gov.mn рүү шилжүүлсэн. Ингэхдээ нийт 240 давхаргыг шилжүүлсэн.</p> <p>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем www.egazar.gov.mn-ны Wild SSL-</p>
--	--	--	--	--	--	---

						<p>ыг энэ оны 01 дүгээр сард сунган холбогдох серверүүд дээр тохируулсан. Архивын цахим системд зарим аймгийн ГХБХБГ-ийн архивын мэргэжилтнүүд хандах үед гарсан алдааг засварлаж үйл ажиллагааны хэвийн байдлыг хангасан. Багаж баталгаажилтын цахим систем www.bagaj.gazar.gov.mn-д багажны дугаар, бүртгэлийн дугаартай зөрсөн алдаа гарсныг түүний өгөгдлийн баазыг засварлаж системийн хэвийн үйл ажиллагааг хангасан.</p>
	6.2.	Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т заасан заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Жилдээ	- Мэдээллийн тоо	- Мэдээлэл шинэчлэгдсэн байна.	<p>Засгийн газрын 2014 оны 384 дугаар тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмын дагуу төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, үнэт цаас, байгууллагатай холбоотой мэдээллийг оруулах албан хаагч нарыг томилон хуулийн хугацаанд мэдээллийг оруулан ажиллаж байна.</p> <p>2021 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2014 оны 384 тоот журамд заасан 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.6, 4.1.9, 4.1.10, 4.1.11, 4.1.12, 4.1.13, 4.1.16, 4.1.18-д заасан мэдээллийг хугацаанд нь оруулсан.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2022 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ болон бусад шийдвэрийг Шилэн дансны тухай хууль болон журамд заасны дагуу шилэн данс хөтлөлтийг тогтмол шинэчлэн ажилласан. 2022 оны жилийн эцсийн байдлаар урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 12 тушаал, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан</p>

						мэдэгдэл 53, зардал гаргасан 49 тушаалыг шилэн дансанд байршуулсан. Байгууллагын батлагдсан орон тоонд ажиллаж буй албан хаагчдын мэдээллийн өөрчлөлтийг 11 удаа шинэчилэн оруулсан.
	6.3.	Холбогдох хууль тогтоомжоор хориглосноос бусад газрын харилцааны мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод нээлттэй болгох	Жилдээ	- Арга хэмжээний тоо	- Ил,тод, нээлттэй болсон байна.	Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй байгаа төрийн байгууллага, хуулийн этгээдийн газрын мэдээллийн egazar.gov.mn системээр олон нийтэд ил тод нээлттэй болгосон. Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2022 оны байдлаар Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөлд сүүлийн байдлаар оролцогч талуудаас санал авах ажлыг зохион байгуулж хуулийн төсөлд саналуудыг тусгасан. Хуулийн төсөлд орон зайн өгөгдлийн дэд бүтцийн мэдээллээс олон нийтэд нээлттэй ил байх мэдээлэл, албан хэрэгцээний мэдээлэл, нууцын мэдээлэл гэсэн төрөлтэй байхаар туссан. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрууд “дундын мэдээллийн сан”-г хамтран байгуулах болсон. Улсын хэмжээнд 4 жил тутамд хийгддэг төрийн байгууллагуудын эзэмшлийн газрын тооллого, бүртгэлийг газрын нэгдсэн цахим систем /www.egazar.gov.mn/-ээр дамжуулан түргэн шуурхай гүйцэтгэх боломжтой болсон. Газрын кадастрын нэгдсэн цахим системд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрыг холбож хамтран ажиллахаар болсон. Улсын нэгдсэн системд бүртгэлтэй байдаг бөгөөд эдгээр иргэн хуулийн этгээдийн хөрөнгийн мэдээллээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар цахимаар лавлагаа авах боломжтой болсон.
	6.4.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах гарч буй олон шат дамжлага, хүнд	Жилдээ	- Арга хэмжээний тоо	- Ил,тод, нээлттэй болсон байна.	2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Цахим хөгжлийн яамны харьяа И-Монгол академи УТУГ-т Газрын нэгдмэл сангийн удирдлагын

		суртлыг арилгах чиглэлээр “Газрын удирдлагын нэгдсэн цахим систем”-ийг улам хөгжүүлж, газрын харилцааны салбарын үйл ажиллагааг цахимжуулах, иргэд, олон нийтэд ил тод нээлттэй болгох				<p>нэгдсэн цахим системээс нийт 7 төрлийн үйлчилгээг бэлтгэн хүргүүлэн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аар дамжуулан хэрэглэнд нэвтрүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Газрын кадастрын нэгж талбарын өргөдлийн мэдээлэл 2. Газрын кадастрын нэгж талбарын гэрээний мэдээлэл 3. Газрын кадастрын нэгж талбарын өргөдлийн явцын мэдээлэл 4. Газрын кадастрын нэгж талбарын өргөдөл гаргагчийн мэдээлэл 5. Газрын үнэлгээний бүсийн мэдээлэл 6. Газрын кадастрын нэгж талбарын ойр орчмын байршлын мэдээлэл 7. Газрын кадастрын нэгж талбарын QR код. <p>Мөн Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс лавлагаа, тодорхойлолтыг нэгдсэн нэг веб үйлчилгээ /сервис/-ээр гаргах шаардлагын дагуу 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа И-Монгол академи УТҮГ-т веб үйлчилгээ /сервис/-ний шинэчлэгдсэн хөгжүүлэлтийг хийн хүргүүлсэн. Тус веб үйлчилгээ /сервис/-ээс нийт 5 лавлагаа, тодорхойлолтын мэдээллийг Төрийн нэгдсэн мэдээллийн систем E-Mongolia-д гаргасан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Газар ашиглах эрхийн лавлагаа 2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагаа 3. Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний лавлагаа 4. Нэгж талбарын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа 5. Нэгж талбарын үнэлгээний лавлагаа зэрэг болно. <p>Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/163</p>
--	--	--	--	--	--	---

							<p>тоот албан бичгээр Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем дээр байршсан газрын харилцааны үйлчилгээг E-Mongolia системд бүрэн холбох тухай, Барилга хот байгуулалтын яаманд 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1/215 тоот албан бичгээр газрын харилцааны бүтээгдэхүүн үйлчилгээг Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-mongolia-д бүрэн шилжүүлэх ажилд, дэмжлэг үзүүлж, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд дээрх асуудлыг уламжлан, богино хугацаанд шийдвэрлүүлэх талаар, Барилга хот байгуулалтын яамны 2022 оны 02 дугаар сарын 24-ны 3/698 тоот албан бичгээр Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-тай холбох сервис үйлчилгээний судалгааг гарган Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд тус тус хүргүүлсэн.</p>
--	--	--	--	--	--	--	--

_ о О о _